

Батсуурийн Анхбаяр^{1,3},[✉]Басандоржийн Буян-Орших²,
Цэрэндоржийн Болорбат¹, Цэндийн Амгалантөгс¹, Гончигийн Батболд¹,

¹Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэн.

Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

²Бие даасан судлаач

³Өвөр Монголын Их Сургуулийн Монгол судлалын сургууль,
Их сургуулийн гудамж, Хөх хот, ӨМӨЗО, БНХАУ, 010020

Ямаан усны өвөлжөөний тамга

Товчлол. Монгол-Хятадын хамтарсан археологийн хээрийн шинжилгээний анги 2018-2019 онд Баянхонгор аймгийн Галуут сумын нутаг, Цагаан Туруут голын хөндийд хайгуул судалгаа хийсэн юм. Энэхүү судалгааны явцад Хан уулын өвөрт орших Ямаан усны амны өвөлжөө хэмээх газраас олдсон нэгэн тамганы тухай энд өгүүлнэ. Бид тус тамганы хэлбэр, хэмжээ, дүрслэлийн арга барил, онцлогийг тодорхойлж, манай орны нутаг дэвсгэрээс олдсон тамга тэмдгийн дүрслэлүүдтэй харьцуулан үзсэний үндсэн дээр Хүннүгийн үед холбогдоно хэмээн үзэж байна.

Түлхүүр үг. Цагаан Туруутын гол, Хүннү, Ямаан усны амны өвөлжөө, Тамга

Ankhbayar Batsuuri^{1,3},[✉]Buyan-Orshikh², Bolorbat Tsendendorj¹,
Amgalantugs Tsend¹, Batbold Gonchig¹

¹Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences Building-1,
Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

²Independent researcher, Mongolia

³School of Mongolian Studies, Inner Mongolia University, No.235
Daxue West road, Hohhot, Inner Mongolia, RP China, 010020

Tamga of winter place Yamaan Usny am

Abstract. In 2018-2019, the Mongolian-Chinese joint archaeological field research team conducted research in the region of Galuut Sum and Tsagaan Turuut River valley in Bayankhongor province. In the course of this research, we presented about a tamga that was found in the Yamaan usny am winter place at the foot of Han Mountain. We determined the shape, size, description method and characteristics of the tamga, based on comparison with the seals found in the territory of our country, we believe that it belongs to the Xiongnu empire.

Keywords. *Tsagaan Turuut river, Xiongnu, Yamaan usny am, Tamga*

Удиртгал

Монгол Улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн (тухайн үеийн нэршлээр), НСИСОУХ болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Соёлын өв, археологийн хүрээлэн хамтран “Монгол улс, БНХАУ-ын хамтарсан археологийн судалгаа” төслийг 2018, 2019 онд хэрэгжүүлсэн билээ. Тус төслийн хүрээнд Баянхонгор аймгийн Галуут сумын нутаг, Цагаан Туруутын голын сав дагуу археологийн хайгуул судалгаа хийж эртний түүх, соёлын дурсгалыг бүртгэх, эрдэм шинжилгээний тодорхойлолт үйлдэх, хайгуул судалгааны дүнд илэрсэн зарим дурсгалд малтлага судалгаа хийж илэрсэн олдвор хэрэглэгдэхүүний холбогдох он цагийг тогтоох, бусад газрын ижил дурсгалуудтай харьцуулан судалж, бүс нутгийн археологийн дурсгалын онцлогийг тодруулах зорилго тавьж ажилласан. Тус төслийн хүрээнд хайгуулын баг Ямаан усны амны өвөлжөөнөөс нэгэн тамга шинээр илрүүлсэнээ TST19-241 дугаартай бүртгэн [Болорбат нар., 2019: 111] баримтжуулсан юм (зураг 1).

Дурсгалт газрын байршил. Ямаан усны ам нь Галуут сумын төвөөс баруун хойд зүгт 20 гаруй км зайд Баяннуур багийн төвөөс зүүн тийш 2 км орчим зайд, умард өргөргийн 460 48' 37,74" зүүн уртрагийн 990 54' 52,25" солбицолд, дтд 2058 м өндөрт оршино. Хан уул хэмээх байгалийн цогцолборт газрын Ямаан усны ам хэмээх гүн хавчиг амны адгийн сайрын хоёр талд Ямаан усны амны өвөлжөө, Хар бууц хэмээх хоёр өвөлжөө бий. Ямаан усны амны өвөлжөөний арын бараан ханан хадан дээр угалзарсан тамга дүрсэлжээ (зураг 2). Энэхүү хаданд тамганаас гадна зүүн тийш харсан 2 янгир, түүний доор баруун тийш харсан 1 адуу, нийт 3 амьтныг тайван зогсож буйгаар дүрсэлсэн сийлмэл зураг бий. Тэдгээрийн дундаас хамгийн том, тод дүрслэлтэй нь 20 x 15 см хэмжээтэй янгир юм. Эдгээр дүрслэлийн баруун дээд талд 100 см орчим өндөрт босоо, угалзарсан хээ бүхий нэг тамга байна. Тамганы хэмжээ 32 см урт, 12 см өргөн бөгөөд дундаа ташуу тигээр тусгаарлагдсан,

тигийн дээр доор тус бүр нэг угалзыг нар буруу эргүүлэн дүрсэлсэн өвөрмөц тэмдэгт ажээ. Тамгыг хадны налуу хэлбэрт захируулан бага зэрэг хазгай сийлсэн боловч алсхан зайнаас тэгш харагдана. Тамганы зураасны өргөн 1 см орчим, гүн бус боловч доорх амьтдын дүрсээс тод ялгаран харагддаг. Тиймээс тамга, амьтдын дүрслэл бүхий хадны зураг нэг цаг үед бүтээгдээгүйг гэрчилж байна.

Хэлэлцүүлэг

Манай орон эртний нүүдэлчдийн үлдээсэн түүх, археологийн дурсгалаар нэн баялаг юм. Түүний нэг нь хад чулуу хийгээд эд өлгийн зүйлс дээр сийлсэн тамга тэмдгийн зүйлс бөгөөд он цаг, дүр дүрслэлийн хувьд харилцан адилгүй байх нь бий. Хад чулуу болон эд өлгийн зүйлс дээр сийлж үлдээсэн тамга тэмдэг бол тухайн овог аймгийн эзэмшил газар, нүүдэл суудлыг гэрчлэн харуулах чухал баримт болдог. Нөгөө талаар тамга тэмдэг нь өөрийн нууцлаг байдлаараа үзсэн харсан хүний сэтгэлийг хөдөлгөн өөртөө татаж байдаг онцгой зүйл юм. Овгийн байгууллын хөгжлийн явцад эртний тамга үүсэхэд зарим нэгэн амьтны мөрийг тамга болгон ашиглаж, улмаар шинэ дүрс нэмэх замаар шинэ тамга эсдэн үүсгэж байжээ [Цэвээндорж, 1999: 52]. Х. Пэрлээ аругай тамга тэмдгийн үүсэл гарлыг эхийн эрхт ёс үүсэхийн хамт, улмаар овог аймгийн дотоодод хөдөлмөрийн хуваарь гарсантай холбогдож бүтээгдэхүүний солилцоонд овгийн тэмдгийн анхны үүсвэр үзэгдсэн бололтой хэмээн эртний хүмүүс аж ахуйн шаардлагаас болон өргөн уудам нутаг тархан нутаглах болсон нь овог аймгийн хүн бүлийг таних, ялгах тэмдэг бий болгох бас нэгэн шаардлага бий болж, тэрхүү шаардлагын үүднээс овог аймгийн им тамга хөгжихөд түлхэц болсон байх хэмээн үзсэн байна [Пэрлээ, 1976: 11].

Тамга тэмдэг нь суурин иргэд гэхээсээ нүүдэлчдэд илүүтэйгээр хэрэгтэй байсан бөгөөд тэдний хувьд өмчийн тэмдэг төдийгүй угсаа гарвацийн хэлхээ холбоог харуулах хууль, эрх

зүйн баталгаа болж байжээ. Мөн овог аймгууд шинээр салбарлах тусам хуучин үндсэн тамганы дүрсэнд нэмэлт зүүлт хийн үүсгэмэл тамга нэмэгдэж байсан байна. Үүний улмаас нийгэм олноороо хэрэглэх ус бэлчээрийг эзэмших, эдлэх эрхээ бататгахын улмаас хад чулуунд нэгэн дор овгийн тамгаа сийлэх явдал байсан хэмээн үзжээ [Пэрлээ, 1976: 10].

Ямаан усны амны өвөлжөөний тамгатай ижилсэх дүрслэлтэй тамга манай орны нутгаас цөөн боловч илэрснийг нийтэлсэн байдаг. Тухайлбал, Ховд аймгийн Үенч сумын нутаг Үенчийн гол, Харгайтын голын бэлчирт, гол руу түрж орсон хадтай хошууны хаданд сүг зураг болон эртний овог аймгийн олон төрлийн тамга тэмдэг бий. Энд янгир, үхэр, морь, тэмээ, хүний дүрс зэрэг сүг зургуудтай. Мөн хадны үзүүрийн хясаанд монгол (тод?) үсгээр бичсэн бичээс ч бий. Энд буй дээрх тамга тэмдгүүд гүнзгий нарийн сийлбэртэй төдийгүй нэг дор олноороо байгаагаас үзэхэд эртний нэгэн чухал зан үйлийн төв байжээ гэсэн сэтгэгдэл төрдөг [Төрбат нар., 2012: 141] гэжээ (Зураг 3. 5).

Ховд аймгийн Үенч сумын нутаг Дунд Жаргалантын хавцлын дунд биед буй цөөн боловч уран дүрслэлтэй хадны зургийн доторх эртний овог аймгийн тамга тэмдгүүдийн заримыг хүннүгийн үеийн язгууртны тамгатай ижил [Төрбат нар., 2012:141] хэмээн үзсэн байна (Зураг 3. 3).

Мөн Ховд аймгийн Алтай сумын Ямаан усны ханан хаданд янгир ямаа, аргаль угалз, буга согоо, морь, хүн, морьтой хүн, зээтүүгээр нөгөөгөө цохиж буй хүн, тэмээ, тэмээн хяруул, зэрлэг гахай, чоно, ирвэс, хандгай, дээрээс нь харуулан дүрсэлсэн 1 тэрэг, 2 морь хөлөглөж сүйх тэргэнд суусан хүнтэй, тэрэгний урд нь нэг морьтой хүн хойно нь мөн нэг морьтой хүн дагасан, бас 1 морь хөлөглөж тэргэн дотор нь хүн суусан, хойно болон урд нь морьтой хүн дагалдсан 2 сүйх тэрэгний зураг зэргийг ихэд урнаар хонхойлгон сийлж дүрсэлжээ. Тэнд гуч орчим тамга тэмдэг дүрслэгдсэний дийлэнхийг хүннүгийн үед хамааруулсны [Төрбат нар., 2012: 142] дотор нэгэн тамга онцгой ялгарна (зураг 3. 4).

Говь-Алтай аймгийн Цээл сумын нутаг Цагаан голын дунд урсгалын бартаа ихтэй хэсэгт голын хойд талын хадархаг дэнж дээрх баруун урагш харсан элгэн хаданд 300 гаруй дүрслэл бүхий сийлмэл зураг байгааг судлаач Ц. Доржсүрэн нар 1955 онд илрүүлжээ. Тэднийг тамга, үсэг, хүн, орон сууц, тэрэг, онго, гэрийн болон зэрлэг мал адгуустай хэмээн ангилаад [Доржсүрэн, 1963: 16, 17, 18] хэлбэр дүрсийн хувьд ялган 39 тамгыг тусгайлан хуулбарласан байна. Ц. Доржсүрэн гуай тэдгээр тамгыг эртний овгийн байгууллын үеийн эсвэл аль нэг эртний улсын үеийн язгууртны тамга

байж болохыг тэмдэглэсэн байдаг (зураг 3. 2). Цагаан голын тамганы заримыг хожим хүннүгийн үед холбогдуулсан юм [Төрбат нар., 2012: 142].

Хүннүгийн тамганы бүтцийн тухайд тусгайлан авч үзсэн судлаач Ц. Төрбат нар үндсэн 2 төрөлд ангилсан байна [Төрбат нар., 2012: 145]. Бидний илрүүлсэн Ямаан усны өвөлжөөний тамганы тухайд дээрх ангиллын “голоор нь шулуун татаж тэгш хуваадаг” хэсэгт оруулах боломжтой санагдана.

Дүгнэлт

Бидний илрүүлэн олсон Ямаан усны амны өвөлжөөний арын хаданд байх тамганы дүрс нь дээр дурдсан дурсгалуудаас илэрсэн тамганы дүрслэлтэй ижилсэж байгаа учир он цагийн хувьд Хүннүгийн үед хамаарах боломжтой юм.

Цагаан Туруутын голын хөндийгөөс жижиг үүдэвтэй том хэмжээтэй цагариг хэлбэртэй булш 10 гаруй, жижиг хэмжээтэй цагариг хэлбэрийн булш 100 орчмыг илрүүлсэн байдаг. Нэг дор хүннү нарын оршуулгын дурсгал болон тамга тэмдэг оршиж байгаагаас үзэхэд Хангайн нурууны өвөр хэсэгт орших Цагаан Туруутын голын хөндий бол хүннү нарын нутаглаж асан төв нутгийн нэг хэмээн дүгнэж болохоор байна.

Ном зүй

Болорбат нар., 2019 - Болорбат Ц., Амгалантөгс Ц., Батболд Г., Лхүндэв Г., Дэлгэрмаа Г., Наранбаатар Д., Анхбаяр Б., Цао Жиан Эн., Сүн Гүо Дүн., Цао Фэн., Цай Си. Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт явуулсан археологийн судалгааны 2019 оны ажлын тайлан. ТАХГБСХ. УБ., 2019.

Давыдова и др., 2003 - Давыдова А.В., Минаев.С.С. Комплекс археологических памятников у села Дурены. // Археологические памятники сюнну. 2003. Вып. №5. СПб.

Доржсүрэн, 1963 - Доржсүрэн Ц. Говь-Алтай Цагаан голын хадны зураг. //Археологийн судлал. Боть II, Дэвтэр 3. УБ., 1963. Тал 16 - 26.

Доржсүрэн, 1961 – Доржсүрэн Ц. Умард хүннү. УБ., 1961.

Пэрлээ, 1976 - Пэрлээ Х. Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь. УБ., 1976.

Төрбат нар., 2012 - Төрбат Ц., Батсүх Д., Баярхүү Н. Хүннүгийн археологийн тамгууд Люаньдо овгийн тамга болох нь. // Studia Archaeologica. Tomus XXXII, fasc. 9. Улаанбаатар. Тал 136 - 161.

Цэвээндорж, 1999 - Цэвээндорж Д. Монголын эртний урлагийн түүх. Улаанбаатар. 1999.

Цэвээндорж нар., 2010 - Цэвээндорж Д., Эрдэнэ-Очир Н., Полосьмак Н.В., Богданов Е.С. Ноён уулын Хүннүгийн язгууртны булшны 2006, 2009 оны археологийн малтлага судалгааны үр дүнгээс. // *Studia Archaeologica*. Tomus XXIX, fasc. 14. УБ., 2010. Тал 255-273.

Өгүүлэл хүлээн авсан: 2023 оны 09 сарын 28

Өгүүлэл засварласан: 2023 оны 11 сарын 26


Өгүүлэл хэвлэгдсэн: 2023 оны 12 сарын 01




Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.



Зураг 1. Дурсгалт газрын байршлын зураг



Зураг 2. Ямаан усны амны өвөлжөөний тамганы гэрэл болон гар зураг



Зураг 3. 1- Ямаан усны амны өвөлжөөний тамга, 2- Цагаан голын тамга, 3- Дунд Жаргалантын тамга, 4-Ямаан усны тамга, 5-Харгайтын голын бэлчрийн тамга